

МОНГОЛ ШИНЭ ЗУУЧЛУУРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Шилингуа*

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн багш

Агуулгын товч:

Дундад Улсад Интернет ба гар утасны зуучлуур зэрэг шинэ зуучлуур бий болоод хориод жил болж байна. Нэн ялангуяа ойрын хэдэн жилд асар хурдацтай хөгжиж, улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн амьдралд маш их нөлөө үзүүлж буй. Үүний нөлөөгөөр монгол шинэ зуучлуур ч гэсэн үүсэж хөгжөөд арван дөрвөн жил болж байгаа бөгөөд хөгжлийн эхний шатандаа байна. Монгол шинэ зуучлуурын үүсэл хөгжлийн явцыг ажиглаж, илүү үр дүнтэй эрхлэн явуулах арга замыг хайх нь монгол үндэстний сонин мэдээллийн үйл ажиллагааны судалгаа болон монгол сонин мэдээллийн хөгжилд зохих ач холбогдолтой юм. Тус өгүүлэлд монгол шинэ зуучлуурын ерөнхий тойм болон судалгааны байдлыг ажиглан хэрхэн үр дүнтэй хөгжүүлэх тухай саанал бодлоо дэвшүүлэв.

Түлхүүр үг: Монгол шинэ зуучлуур, гар утасны зуучлуур, Монгол соёлын сүлжээ, Интернет радио, тоочилсон сонин, электрон уншлагын машин, монгол уусалцсан зуучлуур

1994 онд Дундад Улсад Интернет анх нэвтэрснээс хойш хорин нэгэн жил

болж байна. Хүмүүс энэ хориод жилийг шинэ зуучлуурын цаг үе гэж үздэг. Шинэ зуучлуурын хурдацтай хөгжилт нь Дундад Улсын улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн амьдрал зэрэгт асар их нөлөө үзүүлснээр барахгүй бүх их дээд сургуулийн судлаачид ба зуучлуурын ажилтнуудын анхаарлыг маш их татаж, энэ чиглэлийн судалгаа эрчимтэй хийгдэж байна. Одоогоос арван дөрвөн жилийн өмнө буюу 2001 онд худам монгол үсгийн анхны сүлжээ болох “Монгол соёлын сүлжээ” бий болсноор монгол шинэ зуучлуурын эхлэл тавигдсан гэж үздэг бөгөөд энэ нь монголчуудын соёл, эдийн засаг, өдөр тутмын амьдралд зохих нөлөө үзүүлсэн юм.

Нэг. “Шинэ зуучлуур”-ын ухагдахуун

Шинжлэх ухаан, техник технологийн хурдацтай хөгжилтийг дагалдан гар утасны телевиз, Интернет телевиз, Интернет радио, гадна ханын led дэлгэц (Building TV), тэргэн дээрх шилжээн телевиз (Vehicular Mobile TV), Интернет, мессеж, тоочилсон сонин (Digital newspaper), тоочилсон сэтгүүл (Digital magazine), тоочилсон радио (Digital broadcast), тоочилсон телевиз (Digital television), тоочилсон кино (Digital cinema), блог, бичил бүрэг,

wechat, электрон уншлагын машин (Electronic reading), хавтгай компьютер (Tablet personal computer) зэрэг нь олон нийтийн дунд маш хурдтай дэлгэрч, хүмүүсийн уламжлалт зуучлуур болон шинэ зуучлуурын тухай ухагдахуун балархай болсон төдийгүй “Шинэ зуучлуур”-ын тухай нэгдсэн ойлголт, томъёололд ч хүрээгүй байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын зөвлөлөөс “Шинэ зуучлуур гэдэг нь сүлжээний зуучлуурыг заана”¹ гэж тодорхойлжээ. Миний бодлоор энэхүү томъёолол дэндүү өнгөцхөн болсон тул шинэ зуучлуурын онцлог, төрөл зүйл зэргийг нарийн тодорхойлох нь ихээхэн түвэгтэй юм.

Төвийн ардын радио хорооны Шао Чин Хай: “Шинэ зуучлуур гэдэг бол дижитал технологийн суурин дээр буй болсон өндөр түвшний харилцан үйлдэлцэх шинжтэй, мэдээллийг тасралтгүй солилцдог онцлогтой, олон эшчилсэн хам сураг зангийг дамжуулдаг олон нийтийн нэвтрэлцлийн зуучлуур юм. Голдуу сүлжээний зуучлуур, гар утасны зуучлуур, тоочилсон радио ба телевиз зуучлуурыг багтаана”² гэж тодорхойлсон байна. Миний бодлоор энэ нь нэлээд шинжлэх ухаанч томъёолол боловч тоочилсон радио ба телевиз зуучлуурын хэрэглэгчидтэй харилцан үйлдэлцэх чадамж нь одоо ч гэсэн төдий л түгээмэл биш болохоор тоочилсон радио, телевиз зуучлуурыг шинэ зуучлуурт хамааруулахгүй, харин уламжлалт зуучлуурын технологийн шинэчлэлт гэж үзвэл зохино.

Улсын дотоод дахь шинэ зуучлуурын тухай судалгаа ба сургалт хүмүүжлийн ажлыг хамгийн эрт хийж, шинэ зуучлуурын тухай бичсэн өгүүлэл ба ном бүтээлийн ашиглалтын хэмжээ

хамгийн өндөр байдаг эрдэмтдийн нэг болох Дундад Улсын Ардын Их Сургуулийн Куан Вэнь Бо профессорын үзснээр “Компьютер (эсвэл компьютерийн мөн чанарын онцлогтой тоочилсон төхөөрөмж)-ийг ашиглан сураг занги дамжуулдаг ачаалагч”³ юм. Түүний мөн чанарын онцлог бол тоочилсон шинж ба харилцан үйлдэлцэх шинжтэй. Одоохондоо Интернет, гар утасны зуучлуур ба харилцан үйлдэлцэх шинжтэй тоочилсон телевизийг багтааж буй. Түүний үзэхээр шинэ зуучлуурын “шинэ” бол харьцангуй ухагдахуун, учир нь уламжлалт зуучлуур болох сонин сэтгүүл, радио телевиз анх гарч ирэх үед бүгд шинэ зуучлуур байсан. Үүний адилаар өнөөдрийн ярьж байгаа шинэ зуучлуур ирээдүйд мөн хуучин зуучлуур болно. Иймээс шинэ зуучлуур гэдэг ухагдахуун тасралтгүй хувирах онцлогтой ажээ. Одоогийн байдлаар шинэ зуучлуурыг мэргэжлийн талаас ажиглавал тоочилсон шинжтэй, дамжуулах онцлогоос үзвэл дээд хэмжээний үйлдэлцэх шинжтэй. Олон эрдэмтэн судлаач ба зуучлуурын ажилтнууд дээрх санал, дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Хоёр. Монгол шинэ зуучлуурын тухай судалгааны байдал

Монгол шинэ зуучлуур 2001 онд бий болсон юм. 2000 оноос хойшх эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд монгол шинэ зуучлуурын тухай тусгай өгүүлэл төдий л олон нийтлэгдээгүй бөгөөд монгол сүлжээний зуучлуурын талаарх судалгаа харин харьцангуй их байна. Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Сараалан багш “Өвөр Монголын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр Монголын Үндэстний

Их Сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан”, “Дундад Улсын Монгол судлал”, “Монгол хэл бичиг”, “Монголын судлал” зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлд 2000-2012 оны хооронд нийтлэгдсэн сонин мэдээ судлалын өгүүллийг бүртгэн цуглуулж, “Тус хугацаанд сүлжээний тухай нийт хорин өгүүлэл нийтлэгдэж, “Дундад Улсын монгол сонин мэдээний сүлжээ” ба “Холбоо сүлжээ” зэрэг нь гол судлагдахуун болжээ”⁴ гэж дурдсан байна. Миний бие дээр дурдсан эрдэм шинжилгээний долоон сэтгүүлийн 2013-2015 оны наймдугаар сар хүртэлх хугацаанд нийтлэгдсэн өгүүллүүдийг бүртгэн үзэхэд шинэ зуучлуураар гарчигласан өгүүлэл байхгүй байна. Харин монгол сүлжээний зуучлуурын тухай авч үзсэн, “Үндэстний Их Дээд Сургуулийн оюутнууд Интернет сүлжээг ашигласан байдлын тухай шинжих нь” (“Монголын судлал” сэтгүүл, 2013, №3), “Монгол сүлжээний дотоод дүрмийн өнөөгийн байдлыг дөхөм задлах нь” (“Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2015, №2), “Монгол оюутнуудын сүлжээний хэв боловсролын тухай өгүүлэх нь” (“Дундад Улсын Монгол судлал” сэтгүүл, 2015, №4), “Монгол сүлжээн дэх мэргэжлийн сонин мэдээ мэдээлэгчийн тухай өгүүлэх нь” (“Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2015, № 4) зэрэг дөрвөн өгүүлэл нийтлэгдсэн байна.

Ойрын хоёр жилд “Өвөр Монголын Өдрийн сонин”-ны хорооны эрхэлсэн “Сонин мэдээний судлал” сэтгүүлд монгол сүлжээний тухай өгүүлэл нэлээд олон нийтлэгдэж байгаа ба монгол шинэ зуучлуурын тухай өгүүлэл ч мэр сэр гарч байна. Жишээлбэл, “Монгол шинэ зуучлуурын хөгжлийн

ширвэлт тунгаалт” (2014, №5), “Монгол шинэ зуучлуур – одоохичлолтын хурдан хүлэг” (2014, №5), “Монгол шинэ зуучлуур – Монгол соёлын хүчит жигүүр” (2014, №5) зэрэг өгүүллүүд нь монгол шинэ зуучлуурын талаарх эхлэлийн чанартай судалгаа болжээ.

Ерөнхийд нь авч үзвэл, монгол шинэ зуучлуурын тухай судалгаа эхлэлтийн шатандаа байгаа бөгөөд өргөн дэлгэр, гүнзгий судалгаа хараахан хийгдээгүй байна. Шинэ зуучлуурын доторх монгол сүлжээний зуучлуурын тухай судалгаа нэлээд эрчимтэй явагдаж байгаа боловч монгол гар утасны зуучлуурын тухай судалгаа одоохондоо алга байна.

Гурав. Монгол шинэ зуучлуурын тойм байдал

Дундад Улсын Ардын Их Сургуулийн Куан Вэнь Бо профессорын дурдсан шинэ зуучлуурын тухай томъёолол дээр үндэслэн монгол шинэ зуучлуурыг ажиглавал монгол тоочилсон телевиз, монгол уусалцсан зуучлуур (Fusion media) одоо болтол байхгүй байгаа болохоор монгол шинэ зуучлуурыг монгол сүлжээний зуучлуур болон монгол гар утасны зуучлуур гэсэн хоёр чиглэлээр судлах хэрэгтэй юм.

1. Монгол сүлжээний зуучлуур. 1994 онд Дундад Улсад Интернет сүлжээ нэвтэрч, 1995 онд “Дундад Улсын арилжааны сонин”-ыг хамгийн түрүүнд Интернетэд тавьснаас үндэслэн бодвол, Дундад Улсын сонин үйлсийн тоожуулалт хийх сүвэгчлэлт (Digital exploration) эхлээд нэгэнт хориод жил болж байна. 2001 оны тавдугаар сарын 10-ны өдөр Дундад Улсад худам монгол үсгийн хамгийн анхны сүлжээ болох “Монгол соёлын сүлжээ” Интернетэд тавигдсан. 2006 оны наймдугаар сард Дундад Улсын

монгол хэлний хамгийн анхны сонин мэдээний сайт “Хөлөн буйрын өдрийн сонины сүлжээ” шинээр нээгджээ. “Үүнээс эхлэн “Шинэ малчдын сонин”, “Өвөр Монголын ардын радио нэвтрүүлэг”, “Өвөр Монголын телевиз хороо”, “Дундад Улсын Эв Хамт Намын сонин мэдээ”-ний монгол хэлний сүлжээ зэрэг уламжлалт монгол зуучлуурын сүлжээ ар араасаа байгуулагдаж эхэлсэн”⁵. 2008 оны есдүгээр сарын 28-нд “Дундад Улсын монгол хэлний сонин мэдээний сүлжээ” нээгдэж, “Өвөр Монголын өдрийн сонин”-ы монгол хэвлэл шинэ зуучлууртай болжээ. Одоо Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны сайт, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын сайт, Боловсролын байгууллагуудын сайт, Бизнесийн байгууллагын сайт, Хувь хүний эрхэлсэн сайт зэрэг 200 гаруй монгол сайт байна. Монгол сүлжээ нь монголчуудын үйлдвэрлэл амьдралд нэвтрэн, тооны талаар нэмэгдэн, төрөл зүйлийн хувьд олширч, олон зүйлийн үйлчилгээ үзүүлж, зохих хэмжээгээр хөгжиж байгаа боловч агуулга нь дан цулгүй, шинэчлэлт удаан, хэрэглэгчдийн оролцоо дутмаг зэрэг олон асуудал оршсоор байна.

2. Монгол гар утасны зуучлуур.

Хүн төрөлхтний мэдээллийн нэвтрэлцлийн түүхийг сураг зангийн техник технологийн хөгжлийн түүх гэж хэлж болно. Хэвлэлийн мэргэжил, утасгүй цахилгааны мэргэжил (Radio technology), телевизийн мэргэжил, компью-

терийн сүлжээний мэргэжил нь сонин сэтгүүл, радио, телевиз, сүлжээ зэрэг дөрвөн зуучлуурыг тус тус бий болгосон. Өнөөдөр утасгүй сураг зангийн холбооны мэргэжил, компьютерийн мэргэжил ба сураг зангийн сүлжээний мэргэжлийн нэгдэл нь олон нийтийн шинэ хэлбэрийн зуучлуур болох гар утасны зуучлуурыг бий болгосон байна. “Дундад Улсын Интернет сүлжээний сураг зангийн

төвийн мэдээг үндэслэвэл 2014 оны арван хоёрдугаар сарын байдлаар Дундад Улсад Интернетийг 649 сая хүн, гар утасны Интернетийг 557 сая хэрэглэгч ашиглаж байгаа бөгөөд гар утасны Интернетийн хэрэглэгч нь сүлжээнд нэвтэрч буй бүх хүний 85.8%-ийг эзэлж

байна”⁶.

Монгол гар утасны зуучлуур ойрын хоёр жилд маш хурдацтай хөгжиж байгаа бөгөөд шинж чанараар нь их төлөв сонин мэдээ сураг зангийн шинжтэй, нийгмийн харилцааны шинжтэй, зугаа цэнгээний шинжтэй гэх мэтчилэн гурван төрөлд хувааж болно. Эрхлэн явуулах хэлбэрээр нь албаны ба албаны бус монгол гар утасны зуучлуур гэх хоёр төрөлд хуваан авч үздэг.

Сонин мэдээ сураг зангийн шинжтэй монгол гар утасны зуучлууруудыг ажиглавал 2014 оны наймдугаар сарын 18-ны өдөр “Өвөр Монголын өдрийн сонин”-ы хорооны эрхэлсэн “Сайн уу, Өвөр Монгол” хийгээд “Өвөр Монголын Монгол хэлний гар утасны сонин” гэх гар утасны уншлагын дадалд



Монгол гар утасны зуучлуурыг шинж чанараар нь сонин мэдээ сураг зангийн шинжтэй, нийгмийн харилцааны шинжтэй, зугаа цэнгээний шинжтэй гэх мэтчилэн гурван төрөлд хувааж болно. Эрхлэн явуулах хэлбэрээр нь албаны ба албаны бус монгол гар утасны зуучлуур гэх хоёр төрөлд хуваан авч үздэг



тохируулан хийсэн хоёр шинэ зуучлуур нэвтэрчээ. “Сайн уу, Өвөр Монгол” шилжээ (Client) нь “Дундад Улсын монгол хэлний сонин мэдээний сүлжээ”-ний гар утсанд зориулагдсан хэвлэл бөгөөд хүлээн авагчид монгол хэл дээр бичигдсэн мэдээ мэдээллийг цаг тухайд нь ойлгох боломжийг бий болгожээ. “Өвөр Монголын монгол хэлний гар утасны сонин”-ыг мессеж хэлбэрээр үнэ төлбөргүй дамжуулж байна. Өвөр Монголын Одон телевиз, Өвөр Монголын Ардын Радио Хороо, “Өвөр Монголын өдрийн сонин” (Монгол хэвлэл) ба бүх аймаг хотын монгол сонинууд бас Шинь Лан, Тен Шүний бичил бүрэг, wechat-ыг ашиглан мэдээллийг дамжуулан түгээж байна.

Нийгмийн харилцааны шинжтэй монгол гар утасны зуучлуураас “Голомт” ба “Жиргээ” бичил бүргийг хэрэглэж байгаа хүмүүс нэлээд олон байна. “Дундад Улсын монгол хэлний сонин мэдээний сүлжээ”-ний эрхлэн явуулж байгаа “Голомт” бичил бүрэг нь гар утасны олон хэрэглэгчтэй болсон ба хүлээн авагчид гар утсаараа дамжуулан бичил бүрэг нийтлэх бололцоотой болжээ. Бээжингийн болзоо сод мэргэжил хариуцлагатай хязгаарт компанийн судлан нээсэн гар утасны бичил бүрэг – “Жиргээ” нь 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр албан ёсоор нээлтээ хийсний дараа хэрэглэгчдийн дунд өөрийн гэсэн орон зайг бий болгож чадав. Гэхдээ Шинь Лан ба Тен Шүнь бичил бүрэгтэй харьцуулахад хэрэглэгч цөөхөнтэй, тэр дундаа олны танил хүмүүс төдийлөн ашигладаггүй зэрэг сул талтай. Хэдийгээр агуулга нь өдөр бүр шинэчлэгддэг боловч амар мэнд мэдэлцэх, өдөр тутмын энгийн яриа өрнүүлэх, шүлэглэх, хааяа зураг оруулах, сэтгэгдэл бичих дээр төвлөрч байна.

Бээжингийн “Зугаа” сураг занги мэргэжлийн ажиллах өргөөнийхөн нийгмийн харилцааны гар утасны “Байна уу?” гэх программ хангамжийг судлан бүтээв. Тус программ нь олны сайн мэддэг wechat-тай ойролцоо хэрэглээтэй чимээ холбоо, нийгмийн харилцааны программ хангамж бөгөөд үсэг, зураг, дуу зэргийг харилцан илгээж болдог төдийгүй босоо монгол үсгээр тэмдэглэдэг онцлогтой. Wechat шиг найзын тойрогтой ба эсрэг этгээдийнхээ зөвшөөрлийг олсноор бичгээр харилцаж болдог төдийгүй шингээлтийн даруулыг даран үг ярьж, бас нэг нэгнийхээ оруулсан мэдээ мэдээлэл, сэтгэгдэл, зургийг харж болдог. Гэхдээ одоохондоо wechat шиг олон төрлийн мэдээллийг захиалан унших боломжгүй.

Зугаа цэнгээний (entertaining) шинжтэй монгол гар утасны зуучлуурт “Эгшиг”, “Даваа”, “Тэнгэр тал”, “Шатар”, “Хүүхдийн дуу”, “Шагай” зэрэг багтах бөгөөд эдгээрийн дотроос одоогийн байдлаар гар утасны хамгийн олон хэрэглэгчтэй “Эгшиг” программ хангамж нь хүлээн авагчдад монгол дууг сонгон сонсох боломжийг бүрдүүлж өгөв. Тус программ хангамжийг гар утас болон компьютерийн алин дээр ч ашиглаж болдог.

Үүнээс гадна бас цагаан толгойн үсэг таниулах аппликешин, гар утсанд суулгаж болох монгол хятад толь бичиг мэтийн программууд буй болж байна.

Дөрөв. Монгол шинэ зуучлуурыг үр дүнтэй хөгжүүлэх арга зам

Шинэ зуучлуур нь хүн төрөлхтний нийгмийн нэвтрэлцлийн орчныг хувируулж байгаагаар барахгүй хүмүүсийн амьдралын хэв маяг ба сэтгэхүйн дадлыг ч өөрчилж буй. Монгол шинэ зуучлуур үүссэнээс хойшх арван хэдэн

жилийн хугацаандаа олон талаар амжилт олсон боловч асар хурдтай хөгжиж байгаа зуучлуурын цаг эринтэй зохицон өөрийн гэсэн орон зайг бий болгон бэхжүүлэх нь юун түрүүнд хийх чухал ажил болоод байна. Миний бодлоор зуучлуурын уусалцлыг бодитой биелүүлж, ухуулга сурталчилгааг сайжруулж, хэрэглэгчдийн судалгааг хийснээр илүү сайн хөгжүүлж болно.

1. Уламжлалт зуучлуур болон шинэ зуучлуурын уусалцлыг биелүүлэх. Дижитал технологи болон Интернетийн технологийн хурдацтай хөгжилт нь шинэ зуучлуур үүсэн буй болоход чухал нөлөө үзүүлсэн байдаг. Шинэ зуучлуур буй болсноосоо аваад маш хурдтай хөгжиж сонин, радио, телевиз зэрэг уламжлалт зуучлуур оршин тогтноход тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байна. Ийм нөхцөлд уламжлалт зуучлуур нь шинэ технологийг ашиглаж, мэдээллийн агуулга, нэвтрэлцэх загвар (Communication Model) болон өртгийн загвар (Value format)-аа сайжруулан шинэчилж, уламжлалт зуучлуур болон шинэ зуучлуурын уусалцлыг бодитой биелүүлж чадвал сая хөгжиж чадна. Уламжлалт зуучлуур нь агуулга болон нэр тэмдэгтийн давуу талтай. Зуучлуурын ажилтнууд дижитал технологийг ашиглан нэг мэдээ, сураг зангийг олон янзаар нийтэлж мэдээллийн үнэ цэн ба нөлөө тусгалыг нэмэгдүүлэх боломжтой. Шинэ зуучлуурын давуу талыг баталгаажуулахын тулд олон нийтийн хэрэгцээг хангахуйц, үнэ цэнтэй мэдээллийг нийтлэх шаардлагатай. Иймээс уламжлалт зуучлуур болон шинэ зуучлуурын уусалцал бол зуучлуурын хөгжлийн зайлшгүй хандлага болно. Одоохонд монгол уламжлалт зуучлуур болон шинэ зуучлуурын уусалцлын явц анхны шатандаа байгаа

бөгөөд “Өвөр Монголын өдрийн сонин”-ы хороо энэ тал дээр тэргүүлэн ажиллаж байна. Монгол зуучлуурын уусалцлын тухай “Сонин мэдээний судлал” сэтгүүлд нийтлэгдсэн нэгэн өгүүлэлд “Өвөр Монголын өдрийн сонин”-ы хорооны сурвалжлагч, найруулагч, орчуулагч гар дахь эх бичгээ урьдаар сүлжээнд өгнө, сүлжээнийхэн урьдаар “Мөнх гал” болгоод нийтэлнэ. Дараа өдөр нь сонин дээр гарна. Бусад сүлжээ сонин нь мэдээ зангийн эх баялгийг хамтаар эдэлнэ. Бичил мэдээний тавцангийнхан бас хэсэглэж ангилаад нийтэлнэ. Энэ бол одоогийн байдал. Энэ нь “уусалцах” биш “юүлэх”⁷ гэж дурдсан байдаг. Монгол сонин, радио, телевиз нь цаг үеийн байдлыг дагаж уламжлалт зуучлуур болон шинэ зуучлуурын уусалцан хөгжихийг ахиулж байгаа арга туршлагыг хайн сүвэгчилж бүх талын, олон давхаргат, системжсэн уусалцлыг биелүүлэхээр чармайвал зохино.

2. Ухуулга, зар сурталчилгааг сайжруулах. Монгол шинэ зуучлуурын хэрэглэгчдийн тоо харьцангуй цөөхөн байгаа энэ нөхцөлд монгол шинэ зуучлуурын агуулгын багтаамж, технологийн шинэчлэлтийг тасралтгүй сайжруулж, ухуулга зар сурталчилгааг эрчимтэй хийснээр хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх боломжтой юм. Жишээлбэл, монгол хүн төвлөрсөн сургууль, байгууллагуудын хүрээнд тусгай хөдөлгөөн өрнүүлж, урамшуулал зарлаж, үүгээрээ дамжуулан үйл ажиллагаагаа тэлж, шилжээ буюу гар утасны сонин захиалсан хэрэглэгчдэд бэлэг өгөх зэрэг арга хэмжээ авч болно. Мөн зар сурталчилгаандаа гадны ханын led дэлгэц, нийтийн тээврийн хэрэгсэл ба уламжлалт зуучлуурыг ашиглавал илүү үр дүнтэй байх болов уу. Зуучлуурын

ажилтнууд бас найз нөхөд, төрөл төрөгсөд зэрэг эргэн тойрны хүмүүстээ танилцуулан сурталчлах аргыг хэрэглэвэл зохино.

3. Хэрэглэгчийн судалгаа хийх, тэдний оролцоог нэмэгдүүлэх. Шинэ зуучлуурын хамгийн гол онцлогийн нэг бол хэрэглэгчийн оролцоо юм. Иймээс монгол шинэ зуучлуурын ажилтнууд судалгаа тандалт хийх, асуулт хариултын хуудас тараах зэрэг аргаар монгол хэрэглэгчдийг эрэлт хэрэгцээг мэдэж, тэдний хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээлэл өгөхийг хичээх хэрэгтэй. Үүнээс гадна хэрэглэгчийн оролцоог сайжруулах замаар хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж болно. Олон нийтийн дунд шуугиан дэгдээсэн, дуулиантай асуудлын тухай яриа өрнүүлэх, оролцсон хэрэглэгчдийг шагнаж урамшуулах, хэрэглэгчдийн нийтэлсэн үг, видео зэргээр сонин мэдээний сүвэгч болгох зэрэг аргаар хэрэглэгчдийг идэвхтэй оролцуулж болно.

Дээрх аргуудаас гадна мэдээллийн агуулга болон технологийг сайжруулах, бусдын амжилтаас суралцах, чадвартан элсүүлэх ба хүмүүжүүлэх, шинэ зуучлуурыг хэрхэн үр дүнтэй хөгжүүлэх талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг олон аргаар хайн сүвэгчлэлт хийж болно. “Өвөр Монголын өдрийн сонин” (Монгол хэвлэл)-ы хороо шинэ зуучлуурыг нэн сайн эрхлэн явуулах талаар судлан ярилцах хурлыг удаа дараа, олон янзаар өрнүүлж байна. Энэ бол дэмжүүштэй эхлэл, санаачилга юм.

Ишлэл

¹ 董向东：《新媒体探究》，《软件导刊》教育技术），2013年第2期（下半月），第3页。

² 邵庆海：《新媒体定义剖析》，《中国广播》，2011年第3期，第66页。

³ 匡文波：《新媒体概论》，中国人民大学出版社，2012年9月第一版，第9页。

⁴ *Сараалан*. Шинэ зууны монгол сонин мэдээний судалгааны тойм // “Сонин мэдээний судлал”, 2014, №1, х. 25.

⁵ *Алимаа*. Монгол цахим өртөөний одоох байдал хийгээд хөгжүүлэх арга бодлогын тухай судалгаан // Өвөр Монголын Их Сургуулийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл. 2008, х. 5.

⁶ 罗宇凡：《第35次<中国互联网络发展状况统计报告>发布》，《青年记者》，2015年2月下，第17页。

⁷ *Түмэндалай, Давхарбаяр*. Зуучлуурын уусалцлын цаг үеийг бид яахан угтан буй билээ // “Сонин мэдээний судлал”, 2014, №4, х. 11.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Алимаа*. 2008. Монгол цахим өртөөний одоох байдал хийгээд хөгжүүлэх арга бодлогын тухай судалгаан // Өвөр Монголын Их Сургуулийн магистр цол хамгаалах өгүүлэл. Хөх хот.

2. *Сараалан*. Шинэ зууны монгол сонин мэдээний судалгааны тойм // “Сонин мэдээний судлал”, 2014, №1.

3. *Түмэндалай, Давхарбаяр*. Зуучлуурын уусалцлын цаг үеийг бид яахан угтан буй билээ // “Сонин мэдээний судлал”. 2014, № 4.

4. 向东：《新媒体探究》，《软件导刊》（教育技术），2013年第2期（下半月），第3页。

5. 邵庆海：《新媒体定义剖析》，《中国广播》，2011年第3期，第66页。

6. 匡文波：《新媒体概论》，中国人民大学出版社，2012年9月第一版，第9页。

7. 罗宇凡：《第35次<中国互联网络发展状况统计报告>发布》，《青年记者》，2015年2月下，第17页。

Резюме

Статья посвящена одному из важнейших вопросов современной журналистики Внутренней Монголии – вопросу возникновения и формирования новых медиа и новых интерактивных форм массовой коммуникации на монгольском языке. Автор, анализируя современное состоя-

ние новых медиа, функционирующих вместе с традиционными средствами массовой информации и опираясь на выводы исследователей журналистики этой страны,

делает вывод о том, что пока новые медиа на монгольском языке находятся только на начальном этапе своего развития, поэтому существуют немало нерешённых проблем.